

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(141-146)

МОНГОЛ ШУУДАНГИЙН МАРК БА ӨЛЗИЙН СЭРЭЭТЭР

Б. Сарантуяа*

Монголын урлагийн үнэт өв - анхны марк хэвлэгдсэнээс хойш 91 дэх жилтэйгээ золгож буй энэ жил нэрт филателч Өлзийн Сэрээтэрийн мэндэлсний 100 жилийн ой тохиож бана.

Аливаа улсын марк бол тухайн улсын тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг, урлагийн бүтээл, соёлын үнэт зүйл, түүхэн хөгжлийн баримт, түүхэн үйл явдал, байгаль ан амьтан, ёс заншлыг сурталчлах сурталчилгааны хэрэгслээс гадна цаг хугацаа, судалгаа шинжилгээний нарийн чимхлүүр ажил шаардаж олон хүний хүч хөдөлмөр шингэж бүтдэг шуудангийн үнэт цаас юм. Шуудангийн марк анх Англи улсад 1840 онд тавдугаар сарын 1-нд “Хар пенни” хэмээн алдаршсан /хатан хаан Викториагийн дүрс бүхий/ маркийг зураач Гарольд Хиллийн зурснаар хэвлэсэн. 1926 онд Олон улсын маркийн холбоо байгуулагдсан бөгөөд манай улс 1975 оны 4-р сард гишүүнээр элссэн болой.

Монголын анхны маркийн тухай Монголын Ардын Засгийн Газрын 1923 оны 11-р сарын 23-ний өдрийн 44 дүгээр тогтоол-д

Нэгдүгээр зүйл. Гадаад явдлын яамны цахилгаан мэдээ шуудан бичгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх түшмэл Бат-Очироос аливаа шуудангаар дамжуулан явуулах бичиг захидал дор хэрэглэх, маркийн маяг долоог үйлдүүлж ирсэн, тус ийнхүү үйлдэж болох эсэх, чухам хаана үйлдвээс хэрэг дав дув, санхүү дор арвитай болохыг тогтоон заахыг хүссэн тухайд засгийн газраас хянаж ирүүл гэж зохих газар явуулан тушаажээ.

Эдүгээ харьяат хянан байцаах, сангийн явдлын яамнаас маркийн доллар, цент хэмээх үгсийг гадаад улсын хэрэглэж бүхийг журамлан хэвээр бичих буюу эсбөгөөс монголоор орчуулан төгрөг хэмээн бичих бас ч хэвлүүлэх дор чадах хүнийг, нэмэн хавсаргаж тус хэвлэлийн хорооны чулуун хэвээр үйлдүүлбээс зүйтэй ашигтай хэмээх зэрэг саналыг илтгэн ирсэн учир гаргаж энэхүү маркний үсэг ба маягийг ямар ямараар үйлдүүлэхийг эрхлэх газар тогтоовоос зохино.

Гагцхүү маркийг нарийн нягт үйлдүүлэхгүйгээр үл болох тул харьяат ерөнхий хорооны төлөвлөсөн ёсоор хэвлүүлэх тухай зарцуулах нэг мянга найман зуун алтан төгрөгт тооцох үнийн мөнгө ба нэг мянга хоёр зуун жаран ланг мөнхүү хорооны төлөвлөсөн данснаа нэмэн батлахуй дор татгалзах зүйлгүй хэмээн үг бичиг хуудас нэжгээд, маркийн эх долоогийн хамтаар хүргүүлэн ирснийг хэлэлцээд, энэ хэрэг дор

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

харьяат хянан байцаах хэлтсийн төлөвлөсөн зүйтэй тул ёсоор болгон баталж гадаад явдлын яамнаас эрхлэн гүйцэтгүүлэхийг тогтоов.

Ерөнхий сайд Цэрэндорж

Жинхэнэ орлогч сайд бөгөөд бүх цэргийн жанжин Дэнзэн

Олноо өргөгдсөний арван таван бөгөөд Европын арван нэгэн сарын хорин гуравны өдөр засгийн газраа хурлын олон гишүүд хуралдаж зөвлөлдөн тогтоосон дөчин дөрөвдүгээр хурлын бичиг гэжээ.

Монгол улсын шуудангийн анхны марк 1924 онд гарсан. 1924 оны ҮШ сарын 1-нд 1, 2, 5, 10, 20, 50 цент, 1 долларын нэрлэсэн үнэтэй 5 өнгө ялгасан нэгэн багц маркийг хэвлүүлж гаргасан тухай Цахилгаан шуудангийн ерөнхий хороо, Гадаад Явдлын яамнаас 1924 оны ҮШ сарын 2-ны өдөр Засгийн газарт өргөсөн 42/565 тоот албан бичигт дурьдсан байдаг. Монголчуудын эрт дээр цагаас дийлдэшгүй бат бэхийн бэлгэдэл болгон дээдлэн шүтэж, эрхэмлэж ирсэн “Элдэв-Очир” хэмээх дүрс зургийг анхны маркан дээр залж, тухайн үед үндэсний мөнгөн тэмдэгт хараахан гараагүй байсан тул америк мөнгөний нэгжээр үнэлсэн ажээ.

Монголын анхны шуудангийн маркийн талаар академич Б.Ринчен “Почта и почтовые знаки монголов” /Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир"/1958/ өгүүлэлдээ “Одоо цагийн улс орон бүхэнд мөнгөний цаасан тэмдэггүй улс нэг ч үгүй. Тийм улс байж болно гэж бодоход ч ухаанд багтахгүй байх. Гэтэл мөнгөний цаасан тэмдэгтийг 13-р зууны үеэс тэр үеийн дэлхийн маш уудам газар нийтэд нь монголчууд анх дэлгэрүүлэн хэрэглэсэн түүхтэйг Азийн улс түмний соёлын түүх судлаач цөөхөн хүн мэдэх бололтой...”

Тэр эртний үеийн монгол өртөө шуудангийн зохион байгуулалтын тухай мэдээ 1240 онд Нууц товчооны 279-281-р зүйлд бий. Юан улсын үеийн хууль цаазны бичигт ч бий. Бас түүнээс баахан хожуу үеийн бичиг баримтад бий. Венецийн тэр Марко Поло гэдэг хүн, монгол өртөөгөөр нэлээд явж байсан хүн бөгөөд зам өртөөний байдлыг өгүүлсэн нь: “Хаа ордог зам гэдгийг зам бүхэнд заасан тэмдэг модтой тул явах хүн бүхэн замаа үл алдана.

Их хааны элч нь Хаан балгасаас хаашаа ч мордсон, хорин таван миль тутамд өртөө буюу монголчуудын зам гэдэг газар, манайхаар бол морин өртөө шуудангийн газар байдаг. Өртөө бүрд их хааны элч буух том сайхан байшин гэр бий. Тэр буудлын газар гайхам сайхан торгон хөнжилтэй, жигтэй гоё ор дэвсгэр байдаг. Бас элч хүнд хэрэглэх хамаг юм байдаг тул буухад үнэхээр сайхан байдаг. Өртөө бүрд дөрвөн зуун морь байдаг. Тэр бол их хааны зарлигаар тогтоосон тоо, их хааны хэзээ л элч мордуулбал, өртөөний улаа хэзээд л бэлэн байдаг. Өртөө бүрд нь гурван зуугаас дөрвөн зуун агт морьд хэзээд л бэлэн байдаг. Мужийн гол гол замаар хорин хоёр миль тутамд зарим газар гучин миль болоод өртөө байдаг.

Өртөө бүрд нь 300-аас 400 агт морьд хэзээд бэлэн. Бас буух буудал бэлэн болой. Их хааны бүх харьяа газар нутаг, муж орноор ингэж явдаг, үүнд дэн буудал, хүн харгүй цөл газар их хааны зарлигаар өртөө, сайхан орд харш босгон, агт унаа, эмээл хазаар, хамаг хэрэглэл, юм бүгд бусад өртөөний нэгэн адил бэлдүүлж, гагцхүү өртөө нь хоорондоо арай хол, гучин гурван миль болоод нэг өртөө байх ч бий, зарим газар дөч гаруй миль явж өртөөнд хүрэх газар ч бий. Их хааны элч нь ингэж явдагийг та нар сонсов. Тэр элч хаа ч өртөөгөөр явж буух газар, унах унаа хэзээ ч бэлэн байдаг. Тэр өртөөнийхөнтэй адил сүр жавхлантай, баян тансаг гоёмсог юм ямар ч хаан, хуандий, ямар ч ван ноёд, хэнд ч байгаагүй хэрэг. Тэр олон өртөөнд үнэнийг мэдье гэвэл гурван

бум гаруй агт, явах элчид бэлэн зэхээстэй байдаг бөгөөд буух ордны тоогий нь та нарт хэлбэл түм гаруй бий. Тэр бүгдэд миний нэгэнт хэлсэнчилэн гоё сайхан хэрэглэл бүрэн, тэр гайхалтай гоёлыг хэлж өгүүлэхэд хүч хүрэхгүй тийм сайхан билээ.

Арав хоног дотор тэр өртөөгөөр зуун хоногийн аян хийх газраас мэдээ авдаг юм шүү. Өртөө бүрт бичээч хүн, элчийн хүрч ирсэн өдөр цагийг алгасалгүй тэмдэглэж, элч мордсон өдөр цагийг алдалгүй бичдэг, энэ бол бусад бүх өртөөнд цөм ийм журамтай” гэж гайхан бичсэн билээ...

1924 онд анхны шуудангийн тэмдэгт Элдэв-Очир гэдэг солбисон очиртой зураг зурсан нь, Очир гэж нэгд “бат” гэсэн санаа тул бас очир тэмдэг наасан захиа алдагдалгүй хүрэх “бат” гэсэн санаа бол Энэтхэгээс гаралтай үг бөгөөд уг очир тэмдэг нь цахилгаан гэснийг дүрслэсэн тул монгол цахилгаан шуудангийн анхны бэлгэ тэмдэг нь байжээ. Одоо ч гэсэн гадаад улсын цахилгаан шууданд цахилгааны дүрсээр холбоочны тэмдэг хийдэг ёс буй тул ардын засгийн анхны холбоочны тийнхүү шуудангийн тэмдэгийг монголчуудын олон зуун жил мэддэг, хэрэглэдэг “очир” гэдэг тэмдгийг хэрэглэсэн нь монгол үндэсний хэлбэртэй, интернационалын утгатай тэмдэг хэрэглэсэн нь сонин бөгөөд хойшдоо холбооны тусгай тэмдэг болгож, тэр Элдэв-Очир гэдэг цахилгаан мэт хурдан, алдагдалгүй бат хүргэдэг гэсэн сонин сайхан тэмдэг юмсанжээ.

“Элдэв-Очир” тэмдгээс хойш 1926-1927 оны үеэс Марзан Шарав гэдэг зураач монгол ардын эрх чөлөө, тусгаар тогтнол гэсэн утгатай зураг бүхий соёмбот тэмдэг зурж офсет хэвээр Улаанбаатарт анх удаа монгол шуудангийн тэмдэг хэвлэсэн билээ.” хэмээн бичжээ.

Монголын анхны марк “Элдэв-Очир” нь шинэ монгол улсын гадаад дотоод харилцаанд шинэ цагийн шуудан холбооны нэг чухал гүүр, хөгжлийн анхдагч түүчээ үндэс нь болсон юм.

Монгол маркийг дэлхийд сурталчлахад нэрт филателч Өлзийн Сэрээтэр /1915-2005/ жинтэй хувь нэмэр оруулсан юм.

Өлзийн Сэрээтэр 1915 онд хуучин Түшээтхан аймгийн Бишрэлт гүн, одоогийн Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт төрсөн. 1936-40 онд Ардын ба Хилийн цэрэгт бага дарга, офицер, 1940-50 онд “Эх орны манаа” сонины орлогч эрхлэгч, сэтгүүлч, 1950-52 онд Нисэхийн гаалийн эрхлэгч, 1956-71 онд Улсын архивын газарт архивч, ахлах архивчаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарчээ. Тэрбээр 1947 оноос шуудангийн марк, ил захидал, энгэрийн тэмдэг, цаасан ба зоосон мөнгө, захидлын дугтуй цуглуулж эхэлсэн бөгөөд 1970 оноос шуудангийн марк, захидлын дугтуйгаараа дотоодод 10 удаа, олон улсын улсын болон тив, дэлхийн үзэсгэлэнд 30-аад удаа оролцож алт, мөнгө, хүрэл болон дипломоор тус тус шагнагдсан байна.

Анх 1977 онд Прага хотод болсон “Ил захидлын хуудас-100 жил” үзэсгэлэнгээс дипломоор шагнуулжээ. Гол шагналууд нь;

1988. Шуудангийн маркийн ”Прага”, дэлхийн үзэсгэлэнгээс мөнгөн медаль

1989. Шуудангийн маркийн ”Дели 89”, үзэсгэлэнгээс мөнгөлсөн хүрэл медаль

1991. Шуудангийн маркийн “Токио-91” дэлхийн үзэсгэлэнгээс том мөнгөн медаль

1992. Шуудангийн маркийн “Куала Лумпур -92” дэлхийн үзэсгэлэнгээс том мөнгөн медаль

1994. Шуудангийн маркийн “Сөүл-94” ази тивийн үзэсгэлэнгээс алталсан мөнгөн медаль

1995. Шуудангийн маркийн "Сингапур -95" дэлхийн үзэсгэлэнгээс алталсан мөнгөн медаль

1996. Шуудангийн маркийн "Тайпей-96" Ази тивийн үзэсгэлэнгээс алталсан мөнгөн медаль

1996. Шуудангийн маркийн "Бээжин-96" Ази тивийн үзэсгэлэнгээс алталсан мөнгөн медаль

1999. Шуудангийн маркийн "Хятад-99" дэлхийн үзэсгэлэнгээс том алталсан мөнгөн медаль

2003. Шуудангийн маркийн "Бангкок-2003" дэлхийн үзэсгэлэнгээс том алталсан мөнгөн медаль

2004. Шуудангийн маркийн "Сингапур-2004" дэлхийн маркийн аваргын үзэсгэлэнгээс алталсан мөнгөн медаль тус тус авчээ.

Ө.Сэрээтэрийн "Монгол шуудангийн түүхээс" үзмэр нь энэ төрлийн дэлхийд хуруу дарам цөөн дээд зэрэглэлийн үзмэрийн тоонд зүй ёсоор ордог юм. /"Монголын филатели" сэтгүүл, 2014 он. 28-р тал/

Тэрбээр, шуудангийн маркийн сэдэвчилсэн цуглуулга /марк, ил захидал, зурагт дугтуй, "анхны өдөр" дугтуй, захидлын зурагт цаас/ олон нийтийн байгууллагуудад Хувьсгалын музейд/БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан музейн захиргааны хүсэлтээр/, В.И.Лениний музей, Монголын филателийн холбоо, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл, Батлан Хамгаалах Яам, Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Төв Зөвлөл, УБ хотын Гүйцэтгэх захиргаа, Агаарын тээврийг Удирдах газар зэрэг газруудад тухай тухайн байгууллагын үүх түүх, соёлтой холбоотой монгол шуудангийн марк, дугтуйн иж бүрэн цуглуулга бэлэглэсэн юм.

Нэрт цуглуулагч Ө.Сэрээтэр монгол марк, ил захидал, дугтуйн талаар сурталчилгааны болон эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичжээ. Ө.Сэрээтэрийн арвин баялаг цуглуулга болон түүний амьдралын талаар чех, орос, хятад, болгар зэрэг оронд өгүүлэл хэвлэгдсэнээс гадна "Ардын эрх", "Хөдөлмөр", "Новости Монголий", "Монгол таймс", "Улаанбаатарын мэдээ", "Ням гариг", "Үнэн", "Найрамдлын зам", "Пионерийн үнэн", "Залуучуудын үнэн" зэрэг сонинд судлаач, сурвалжлагч Г.Раднаабазар, Чи.Болд, Л.Цэвээндорж, Н.Баарай, Г.Ловор, Ү.Хүрэлбаатар, Р.Чулуун, Эрдэнэсүх, Д.Бат-Эрдэнэ, Г.Зориг нарын хүмүүс сурвалжлага, нийтлэл, тэмдэглэл бичиж хэвлүүлсэн байна.

Монголын анхны марк "Элдэв-Очир"-ын талаар Ө.Сэрээтэр "Анхны монгол марк" /2002/ өгүүлэлдээ "Өнө эртнээс өртөө шуудангийн арвин түүхтэй Монгол оронд 1920-иод оны дундуур буй болсон шинэлэг хэдэн зүйлийн нэг нь шуудангийн үндэсний марк гарсан явдал билээ. Олон улсын шуудан харилцааны нийтлэг журмаар шаардагдсан энэхүү маркийг бий болгох тухай асуудал бүр 1922 оноос эхлэн тавигджээ... Элдэв-Очир нэртэй анхны монгол марк хэвлэгдэн гарсан нь Монгол шуудангийн түүхэнд шинэ хуудас болсноор барахгүй шуудан харилцааны орчин үеийн үйлчилгээг өндөр соёл, итгэмжит баталгаатай болгож, тусгаар тогтносон монгол улсын алдар хүндийг дэлхий нийтэд зарласан нэгэн шинэ тунхаг болсон юм." хэмээн бичжээ.

Монголын анхны марк Элдэв-Очирын тухай судалгааг Г.Чулуунгомбо, Ч.Болд, Ш.Чадраабал, Ч.Содоо нарын судлаачид үргэлжлүүлэн бичсэнээс монголын филателийн холбооны гүйцэтгэх захирал Ш. Чадраабал, залуу судлаач Ч.Содоо нар монгол маркийн 90 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд /2014.10.09/ хэлэлцүүлсэн "Монголын анхны шуудангийн маркийн тухай хэдэн асуулт" хэмээх илтгэлдээ "Элдэв-Очир"-ын

дунд буй сүрэг тамга, маркийн агуулга, утга санааны талаар сонирхолтой санал дэвшүүлсэн болно.

Монголын анхны марк хэвлэгдэж шуудан харилцаанд орсноос хойш есөн арван жил улиран оджээ. Анхны марк “Элдэв-Очир”-оос хойш 2015 оны 5 сарын 15-ны байдлаар 995 сэдвээр, 4001 нэрийн марк гүйлгээнд гаржээ. Монгол шуудан компани, Монгол маркийн газраас Монгол Улсын хамгийн отгон марк “Аугаа эх орны дайнд ялсны 70 жил ” /Победа в великой отечественной войне-70 лет/сэдэвт маркийг энэ оны 5 сарын 4-нд Аугаа эх орны дайны ялалтын 70 жилийн ойд зориулан гаргасан бөгөөд манай улс удахгүй маркийн хөгжлийн 91 дэх жилдээ *Мянга дахь маркаа* баяр ёслол төгөлдөр, амжилт бүтээл дүүрэн угтан авах гэж байна.

Марк нь тухайн улсын түүх, соёл, ахуйн амьдрал, ан амьтан, ургамлын гэх мэт олон дүр зураг, төрхийг агуулахаас гадна шинжлэх ухааны салбаруудад харилцан уялдаа холбоог үүсгэж байдаг салшгүй нэг хэсэг нь юм. Аливаа шинжлэх ухааны нээлт бүтээлүүдийн шилдэг төрөл зүйлүүдийг марк онцолж байдаг. Марк нь тухайн улсын түүх, соёл, ахуйн амьдрал, ан амьтан, ургамлын гэх мэт олон дүр зураг, төрхийг агуулахаас гадна шинжлэх ухааны салбаруудад харилцан уялдаа холбоог үүсгэж байдаг салшгүй нэг хэсэг нь юм. Аливаа шинжлэх ухааны нээлт бүтээлүүдийн шилдэг төрөл зүйлүүдийг марк онцолж байдаг.

Монгол шуудангийн маркийн хөгжил нь Монгол улсын хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой төдийгүй Монгол улсын нэр хүнд олон улсын харилцааны түүхэнд ч онцгой байр суурь эзэлсээр байгаа билээ.”хэмээн /“Монгол маркийн 90 жил”илтгэл/дээ онцлон хэлсэн юм.

Манай улсын шуудан харилцаа, маркийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж гавьяат үйлс бүтээсэн Ө.Сэрээтэр, Г.Раднаабазар, Д.Вандандорж, Д.Дашжав, Ч.Энхбат, Г.Ловор, Х.Гунгаажав, Н.Чинбат, Б.Алтангэрэл, Д.Мишээл нарын олон хүн, мөн маркийн үе үеийн зураачид, тэр дундаа филателийн хөдөлгөөний түүхэнд нэр нь үүрд дурсагдах Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн Өлзийн Сэрээтэр гуайн үйлс бүтээлийг олонд сурталчлах түгээхэд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Мөн монгол марк бол монголчуудын утга соёл, эрдэм ухааны чухал өв болохыг түүх судлал, түүх бичлэг, угсаатны зүй, монгол хэл, хэл шинжлэл, нэр томьёо, биологи, газар зүй, археологи, антропологи, соёл судлал, уран зураг, гоо зүй, сэдэвчилсэн ангилал гэх мэт олон талаас нь судлан шинжилж монгол марк судлалыг улам өргөн хүрээтэй далайцтай, хүртээмжтэй болгох шаардлагатай байгаа юм.

НОМ ЗҮЙ

1. Ринчен Б. (1958), “Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир”, “Утга зохиол сонин”, 1991. № 18.
2. Ринчен Б. (1968), “Захидал харилцааны боловсрол чухал болж байна (“Хөдөлмөр” сонин. 12.12. № 149)
3. Болд Ч. (2007), Монгол маркийн түүх, Улаанбаатар.
4. Болдхэт С. Чадраабал Ш. (2014) Монголын ууган филателч Өлзийн Сэрээтэр, түүний филателийн үйл ажиллагаа. “Монголын филатели” сэтгүүл., № 2,3. Улаанбаатар.

5. Ганболд Д. (2014), Монгол маркийн 90 жил. Монголын филатели сэтгүүл, № 2
6. Гунгаажав Х. (1963), Шуудангийн марк цуглуулагч нарт тусламж Улаанбаатар.
7. Дашжав Д. (1993), Монгол марк цуглуулагчдын товч лавлах, Улаанбаатар.
8. Ловор Г. (1998), Монголын филателийн холбооны хүндэт гишүүн Өлзийн Сэрээтэр. Улаанбаатар.
9. Монголын филатели сэтгүүл. (2004) № 1.
10. Монголын филатели сэтгүүл. (2014) № 2, 3
11. Sarantuya В. (2014), Mongolian postage stamp, This is UB. УБ.. # 1, p 38-41
12. Чадраабал Ш., Содооч. (2014), “Монголын анхны шуудангийн маркийн тухай хэдэн асуулт”, /Монголын филатели сэтгүүл. № 2, 3/

РЕЗЮМЕ

За девять десятилетий со дня появления первой монгольской марки "Элдэв-Очир" /1924/, имеющей начало с ямской почты Монголии, изданы марки более чем по 995 коллекциям.

Огромная роль в деле популяризации монгольских марок в мировом пространстве принадлежит заслуженному деятелю искусства Ө.Сэрээтэр /1915- 2005/, заниматься филателией он начал с 1947 года. Он коллекционировал не только марки, но и открытки, значки, монеты и денежные знаки. Ө.Сэрээтэр со своей коллекцией "Из истории почты Монголии" принял участие в десятках мировых, континентальных соревнованиях, откуда он привёз к себе на родину первую золотую медаль. Он первый выдающийся пропогандист, писавший о значимости коллекционирования. Ө.Сэрээтэр поистине является выдающимся человеком, чьё имя навечно должно вписаться в историю развития монгольской филателии.